

Төв аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (2015 оны 1 дүгээр сарын байдлаар)

I. Нийгмийн үзүүлэлт




I.1 Бүртгэлтэй ажилгүй иргэн.

2015 оны 1-р сард Хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 592 болж, 2014 оны мөн үеэс 692 хүнээр буурч, өмнөх сарынхаас 15 хүнээр өсөв.

Ажилгүйчүүдийн 49,32 хувь буюу 292 нь эмэгтэйчүүд юм. 2015 оны эхний сард ажлын байр захиалгад бүртгэгдсэнгүй. Зуучлалаар 13 ажлын байранд иргэд ажилд оров. Ажилд зуучлагдсан иргэдийн 38,46 хувь буюу 5 нь эмэгтэйчүүд байна.

Зураг I.1

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон иргэд, жил бүрийн 1 дүгээр сарын эцсийн байдлаар




Тайлант сард бүртгүүлсэн 195 ажилгүй иргэний 24,6 хувь нь сургуулиа төгссөн, чөлөө авсан; 21,0 хувь нь цалин орлого хүрэлцэхгүй байгаа; 16,9 хувь нь орон тооны цомхтголд орсон; 15,4 мэргэжил ур чадвараа ашиглан орлогоо нэмэгдүүлэх; 6,2 хувь нь өөр газраас шилжин ирсэн; 4,6 хувь нь өрхийн болон хувийн аж ахуй эрсдэлд орж орлогогүй болсон; 3,6 хувь нь одоо эрхэлж байгаа ажлаа солих хүсэлтэй; 2,1 хувь нь байгууллага татан буугдсан; 1 хувь нь цэргээс халагдсан; 0,5 хувь нь хорих газраас суллагдсан, 4,1

хувь нь бусад шалтгаанаар тус тус бүртгүүлжээ.

Ажилгүйчүүдийг боловсролын төвшинээр хуваавал 2,87% нь дээд; 12,33% нь тусгай дунд; 42,91% нь мэргэжлийн анхан шатны; 11,99% нь бүрэн дунд; 5,41% нь бүрэн бус дунд боловсролтой; 23,82% нь бага; 0,68% нь боловсролгүй иргэн байна.

Зураг I.2

Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр, 2015 оны 1 дүгээр сарын эцсийн байдлаар



Эх үүсвэр: Хөдөлмөрийн хэлтсийн сар бүрийн мэдээ

*- Ажил хайгч гэж ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн иргэнийг ойлгоно.



I.2 Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын байгууллагын мэдээгээр 2015 оны эхний 1 сард НДШ-ийн орлого 870.2 сая ₮ болж төлөвлөгөө 80.5 хувь болж, төлөвлөгөөг Борнуур сум 7.39 хувиар давуулан биелүүлж, бусад сум 26.98-4.92 хувиар тасалдууллаа. Сайн дурын НДШ-ийн орлого 38.1 сая ₮ болж төлөвлөгөөг бүх сум 27.98-15.86 хувиар тасалдууллаа.

Тэтгэвэр, тэтгэмжинд 2.6 тэрбум ₮ зарцуулж, олголт 100.0 хувь боллоо.

Олгосон тэтгэвэр, тэтгэмжийн 80.2 хувийг өндөр настны, 10.5 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 3.9 хувийг тэжээгчээ алдсаны, 5.4 хувийг цэргийн тэтгэвэрт тус бүр зарцуулжээ.

Нийгмийн даатгалын сангаас олгосон дундаж тэтгэвэр 238420 ₮ боллоо.

Нийгмийн даатгалын нийт зарлагын 37.64 хувийг орлогоороо бүрдүүлснээс тэтгэврийн даатгалын сангийн 27.76%; тэтгэмжийн даатгалын сангийн 83.78%; эрүүл мэндийн даатгалын сангийн 83.12%; үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн 312.59%; ажилгүйдлийн даатгалын сангийн 62.78%-ийг тус бүр бүрдүүлжээ.

Нийгмийн халамж

Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн мэдээгээр 2015 оны эхний 1 сард нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламжийг 37592 хүнд олгож, 1.0 тэрбум ₮-ийг зарцуулж 2014 оны мөн үеэс хүний тоо 3.65 хувь 1426 хүнээр буурч, зарцуулсан мөнгөний хэмжээ 16.70 хувь 148.9 сая ₮-өөр өслөө.

Нийгмийн халамжийн дундаж тэтгэвэр 81620 ₮ болжээ. Олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламжийн 59.99 хувийг хүүхдийн хөгжил сангийн мөнгө; 17.03 хувийг халамжийн тэтгэвэр; 4.01 хувийг жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж; 3.79 хувийг төрөл бүрийн нөхцөлт мөнгөн тусламж; 14.37 хувийг нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж; 0.60 хувийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн хамгааллын хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт, тусламжид тус бүр зарцуулжээ.




1.3 Эрүүл мэнд

2015 оны эхний 1 сард 1422 өвчтөн эмнэлэгт хэвтэн эмчлэгдэн гарсан нь нэг өвчтөнд дунджаар 7.5 ор хоног ногдлоо.

Эрүүл мэндийн байгууллагын мэдээгээр 2015 оны эхний 1 сард 93 хүүхэд мэндэлсэн нь 2014 оны мөн үеэс 38 хүүхдээр буурлаа.


Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар.



Аймгийн хэмжээнд 2015 оны 1 сарын байдлаар нялхсын эндэгдэл 1 хүүхэд гарч өмнөх оны мөн үеэс 1-ээр өссөн байна. 5 хүртлэх насандаа эдсэн хүүхэд гараагүй байна.

Зураг 1.4

Эндсэн хүүхдийн тоо, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар




2015 оны эхний 1 сард нийт гарсан халдварт өвчнөөр 45 хүн өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 55.5 хувь буюу 20 хүнээр буурлаа. 2014 оны мөн үеэс трихомениаз 2.5 дахин, тэмбүү 4 дахин, тус бүр буурчээ. 10000 хүнд ногдох

өвчлөл аймгийн дундаж 5 байгаа бол: Цээл 20, Зуунмод 17, Баян 15, Сүмбэр 11, Борнуур 8, Баянцагаан 6, ногдлоо.

Зураг 1.5

10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар



1.4 Байгаль орчин

Цаг агаарын тойм, агаарын бохирдол

- агаарын дундаж температур 12-20 градус хүйтэн буюу Дэлгэрхаан, Эрдэнэсант орчмоор хүйтний эрч сулавтар, Мөнгөнморьт, Батсүмбэр орчмоор хүйтэн байв.

- өдөр ажиглагдсан агаарын хамгийн дулаан температур 5 градус дулаанаас 3 градус хүйтэн, Дэлгэрхаан орчмоор 5 градус дулаан, нутгийн зүүн хойд хэсэг буюу Мөнгөнморьт, Угтаал орчмоор 3 градус хүйтэн байв.

-шөнийн хугацааны агаарын хамгийн бага температур -26-34 градус хүйтэн буюу Дэлгэрхаан орчмоор -26 градус, Бүрэн, Мааньт, Алтанбулаг, Батсүмбэрд -34 градус хүйтэн байна.

-бүх нутгаар сарын нийлбэр хур тунадас 0,0-3,9 мм, үүнээс хамгийн их нь Заамарт 3,9 мм, Борнуурт 3,2 мм, Жаргалантад 2,6 мм, Угтаалд 2,4 мм, Дэлгэрхаанд 2,1 мм цас оржээ.

-салхины их хурд нийт нутгаар 4-12 м/с, зарим газраар түр зуур 16-18 м/с хүрлээ. Олон жилийн дундажтай харьцуулсан

дүгнэлт. 2014 оны 1-р сард цас бага орсон боловч өвлийн сарууддаа цас ихтэй, жиндүү хүйтэн байсан байна. Харин 2015 оны 1-р сард 2014 оныхоос газар тариалангийн зарим нутаг, Дэлгэрхаан, Баян-Өнжүүл, Зуунмод орчмоор 0,3-1,5 мм-ээр ахиу, бусад сумдад бага цас орж, агаарын температур өвлийн сарууддаа сулавтар байлаа. Өмнөх оны 1-р сараас цасан бүрхүүл ойролцоо, нутгийн өмнөд хэсгээр сарын ихэнх хугацаанд цас ороогүй боловч, 28-нд цас орсон.

Цаг агаарын үзүүлэлтүүдийг 2014 оны 1-р сартай харьцуулахад:

-агаарын дундаж температур бүх нутгаар 1-5 градусаар дулаан

-өдрийн хамгийн их температур бүх нутгаар 1-5 градусаар дулаан

-шөнийн хамгийн бага температур ихэнх нутгаар 1-6 градусаар дулаан, Баянжаргалан орчмоор 1 градусаар хүйтэн ажиглагдсан

-сум тус бүрээр тунадасны нийлбэрийг гаргаж үзэхэд өмнөх оны 1-р сараас нутгийн зүүн өмнөд хэсгээр болон Баян-Өнжүүл, Дэлгэрхаан, Заамар орчмоор 0,3-1,8 мм-ээр ахиу, бусад нутгаар 0,2-1,9 мм-ээр бага оржээ.

Энэ оны 1-р сард 2014 оны 1-р сараас цас арай бага орж, өвлийн ихэнх саруудад хүйтний эрч сулавтар, цаг агаар тогтвортой байлаа. Одоогийн байдлаар ихэнх нутгаар цастай байгаагаас, Борнуур, Батсүмбэр, Баянчандмань, Эрдэнэ, Жаргалант, Угтаал, Батсүмбэр, Сүмбэр, Баянцогт сумдад /өртөө харуулын талбай дээрх хэмжилтээр/ 5-13 см зузаан нягтарч хатуурсан зузаан цастайгаас малын бэлчээрлэлт хүндрэх нөхцөл бүрдээд байна. Цаашид 2 дугаар сард дээрх нутгуудад цасны зузаан нэмэгдэж, улам нягтарч хатуурвал малын

бэлчээрлэлт хүндэрч болзошгүй байгааг онцгой анхаарна уу.

2015 ОНЫ ХОЁРДУГААР САРЫН ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ

Төв аймгийн нутгаар. Энэ сарын агаарын температурын дундаж нь 15-20 градус хүйтэн буюу дунджийн орчим байх төлөвтэй.

Хүйтний эрч сулрах үе: Нэг ба гуравдугаар арав хоногийн сүүлийн хагаст Туул голын хөндийгөөр шөнөдөө 23-28, өдөртөө 9-14 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 15-20, өдөртөө 3-8 градус хүйтэн.

Хүйтний эрч чангарах үе: Харин хоёрдугаар арав хоногийн эхний хагаст хүйтний эрч чангарч Туул голын хөндийгөөр шөнөдөө 31-36, өдөртөө 19-24 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 25-30, өдөртөө 13-18 градус хүйтэн байна.

Бусад хугацаанд: Туул голын хөндийгөөр шөнөдөө 23-28, өдөртөө 12-17 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 18-23, өдөртөө 7-12 градус хүйтэн байна.

Энэ сард орох цасны хэмжээ нь Төв аймгийн баруун өмнөд хэсгээр олон жилийн дунджийн орчим, бусад нутгаар дунджаас ахиу байх төлөвтэй. Дундаж нь нутгийн зүүн өмнөд хэсгээр 0,2-1,5 мм, бусад нутгаар 1,5-2,5 мм байдаг. Нэгдүгээр арав хоногийн эхэн болон нэг ба гуравдугаар арав хоногийн дунд үеэр нутгийн хойд хэсгээр бага зэргийн цас орно. Хоёрдугаар арав хоногийн эхэн ба сүүлчээр ихэнх нутгаар, гуравдугаар арав хоногийн эхээр зарим газраар цас орно. Энэ үеүдэд зарим нутгаар салхи баруун хойноос 12-14 м/с, ялангуяа хоёрдугаар арав хоногийн эхэн болон сүүлч, гуравдугаар арав хоногийн эхээр нутгийн өмнөд хэсгээр 16-18 м/с хүртэл ширүүсч

цасан болон шороон шуурга шуурах төлөвтэй.

ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛД ХЭРХЭН НӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

2 дугаар сарын цаг агаарын урьдчилсан мэдээгээр агаарын дундаж температур нутгийн өмнөд хагаст олон жилийн дунджаас дулаан, Эгийн голын хөндий, Бүтээлийн нуруу орчмоор дунджаас хүйтэн, бусад нутгаар дунджийн орчим, хур тунадас ихэнх нутгаар олон жилийн дунджийн орчим ба түүнээс ахиу, Говь-Алтай, Баянхонгорын нийт нутгаар, Ховд, Завхан, Өвөрхангай, Дорнод, Өмнөговь, Дорноговийн зарим нутгаар дунджаас бага орох төлөвтэй байна. Одоогийн байдлаар нутгийн 50 гаруй хувьд цасан бүрхүүл тогтсоноос Увсын Хяргас, Хөвсгөлийн Цагаан-Үүр, Эрдэнэбулган, Ренчинлхүмбэ, Булганы Тэшиг, Сэлэнгийн Түшиг, Зүүнбүрэн, Цагааннуур, Орхон, Сүхбаатар, Ерөө, Хүдэр, Дарханы Дархан, Хонгор, Орхон, Шарынгол, Сүхбаатарын Асгат сумдад 10-25 см зузаан цастай байна. 2 дугаар сард цасан бүрхүүл тогтсон нутгаар цаашид цасны зузаан нэмэгдэж, нягтарч хатуурвал малын хариулага маллагаа хүндрэхээр байна. Мөн түүнчлэн сарын дундаас хойш хүчтэй цасан шуурга шуурч малын хариулга маллагаанд хүндрэл учруулж болзошгүйг онцгой анхаарна уу

2015 ОНЫ ГУРАВДУГААР САРЫН ЦАГ АГААРЫН ТӨЛӨВ

Энэ сарын агаарын температурын дундаж нь ихэнх нутгаар 5-10 градус хүйтэн буюу дунджийн орчим байна. Энэ сард орох хур тунадасны хэмжээ нь ихэнх нутгаар олон жилийн дунджаас ахиу байна.




1.5 Гэмт хэрэг

Цагдаагийн байгууллагын мэдээгээр 2015 оны эхний 1 сард аймгийн хэмжээнд 76 гэмт хэрэг бүртгэгдэж 55 хүн холбогдож төр, иргэдийн өмчид 125.1 сая ₮-ийн хохирол учирлаа.

Зураг 1.8

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар



Зураг 1.9

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо, жил бүрийн 1 дүгээр байдлаар



Гарсан гэмт хэргийн 48.68 хувь нь хулгай, 28.95 хувь нь иргэний эрүүл мэнд эрх чөлөөний -ний хэрэг, 11.84 хувь нь бусад хэрэг. 5.26 хувь нь замын осол, 2.63 хувь нь танхай дээрэм, 2.63 хувь нь хүний амийн хэрэг тус бүр эзлэв. Сэргэлэн, Баяндэлгэр, Заамар, Баянжаргалан, Батсүмбэр сумдад 10000 хүнд 45-23 гэмт хэрэг ногдсон нь аймгийн дунджаас (8)-аас харьцангуй их байна.

Гэмт хэргийн тоо 2014 оны мөн үеэс 19 хэргээр буурлаа.


Зуунмод суманд 3 эмэгтэй, 79 эрэгтэй нийт 82 хүн эрүүлжүүлэгдсэн нь 2014 оны мөн үеэс 25 хүнээр буурлаа.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, сая төгрөгөөр.



1.6 Шүүхийн шийдвэр гүйцэтгэл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны 2015 оны эхний 1 сарын мэдээгээр ажиллагаа хийгдэж байгаа 213 гүйцэтгэх хуудсанд нийт 1.22 тэрбум ₮-ийн төлбөр тэтгэлэг ногдов. Үүнээс 8 гүйцэтгэх хуудсанд ногдох 161.6 сая ₮-ийн материалд шүүхийн байцаан шийтгэх ажиллагаа хийгдэж, биелүүлбэл зохих 205 гүйцэтгэх хуудасны 1.05 тэрбум ₮-өөс 27 хуудасны 132.7 сая ₮-ийг биелүүлж, бодит биелэлтийн хувь гүйцэтгэх хуудасны тоогоор 13.17 хувь, үнийн дүнгээр 12.52 хувь болж 2014 оны мөн үеэс гүйцэтгэх хуудасны биелэлт 6.52 нэгжээр, үнийн дүнгийн биелэлт 6.46 нэгжээр тус тус өслөө.



II. Эдийн засгийн үзүүлэлт



II.1 Мөнгө, зээл, хадгаламж

ХААН, Хас, Төрийн банкны салбаруудын дүнгээр 2015 оны эхний 1 сард кассын орлого 23.9 тэрбум ₮, кассын зарлага 24.2 тэрбум ₮ болж, гүйлгээнд 1.8 тэрбум ₮ байна. ХААН, Хас, Төрийн банкны салбарууд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад жижиг худалдаа, үйлдвэрлэлийг дэмжих үүднээс бичил бизнес болон нийт олгосон зээлийн үлдэгдэл 2015 оны эхний 1 сарын байдлаар 120.6 тэрбум ₮, байгаа нь өмнөх оны эцсээс 2.5 тэрбум ₮-өөр өслөө. 2015 он гарсаар Засгийн газраас бичил бизнесийг дэмжих ажлын хүрээнд зээлдэгч нарт 13.0 тэрбум төгрөгийн зээл олгожээ. Иргэдийн хувийн хадгаламжинд 1 сарын 31-ний байдлаар 41.0 тэрбум ₮ байна. Харилцах дансны үлдэгдэл 1 сарын 31-ны байдлаар 260641 иргэний 8.8 тэрбум ₮ боллоо. ХААН, Төрийн, Хас банкны салбарууд иргэдийн хадгаламжинд төлж байгаа хугацаатай дээд хүү 1.34-1.35 хувь, хугацаатай доод хүү 0.65-0.70 хувь, хугацаагүй дээд хүү 0.60-0.61 хувь, хугацаагүй доод хүү 0.50-0.58 хувьтай байна.



II.2 Төсөв, мөнгө

Төсвийн орлого 2015 оны эхний 1 сард орон нутаг ба аймагт төвлөрүүлснээр орлого 553.4 сая ₮, зарлага 2.6 тэрбум ₮ болж, аймаг, орон нутгийн төсвийн орлогоор тооцоход орлогын төлөвлөгөө 90.22 хувь биелэгдэж, үндсэн нэрийн татварын орлогуудаас, Хувь хүний орлогын албан татвар, газрын төлбөр, бусад төлбөр, хураамж, хүү торгуулийн орлого, түрээсийн орлогын төлөвлөгөө биелэгдсэнгүй. Аймагын төсвийн орлого


2014 оны мөн үеэс 38.67 хувь буюу 349.0 сая ₮-өөр буурлаа. Аймагын төсвийн орлогын 70.22 хувийг татварын, 29.59 хувийг татварын бус, 0.20 хувийг хөрөнгө борлуулсны орлогууд бүрдүүлж байгаа нь 2014 оны мөн үеэс татварын орлого 20.43 нэгжээр буурч, татварын бус орлого 20.25 нэгжээр өсч, хөрөнгө борлуулсны орлого 0.19 нэгжээр буурлаа. Аймагын нийт 3 шатны орлого 810.8 сая ₮ болж аймагийнх 399.2 сая ₮ буюу 49.24 хувь, сумынх 154.3 сая ₮ буюу 19.03 хувь, улсынх 257.3 сая ₮ буюу 31.73 хувийг тус бүр бүрдүүлжээ.

2014 оны мөн үеэс төсөвт байгууллагуудын өглөг 2.24 дахин буюу 718.8 сая ₮-өөр өсч 1.0 тэрбум ₮, авлага 17.60 хувь буюу 17.7 сая ₮-өөр өсч 118.4 сая ₮ боллоо.

Орон нутгийн төсвийн орлого 488.6 сая ₮ болж, төлөвлөгөө 89.94 хувиар биелэгдэж. Суманд төвлөрүүлэх төсвийн орлого 154.2 сая ₮ болж, төлөвлөгөө 242.16 хувь биелж, Батсүмбэр, Дэлгэрхаан, Баянхангай, Мөнгөнморьт, Баян-Өнжүүл, Алтанбулаг, Өндөрширээт, Аргалант, Угтаал, Зуунмод 73.83-0.19 хувиар тасалдууллаа.

Аймагт төвлөрүүлэх төсвийн орлогын төлөвлөгөө 399.1 сая ₮ болж 72.62 хувь биелж, Өндөрширээт, Баянцагаан, Дэлгэрхаан, Алтанбулаг, Баянжаргалан, Сэргэлэн, Сүмбэр, Заамар, Баянхангай, Баян-Өнжүүл, Цээл, Мөнгөнморьт, Архуст, Эрдэнэсант, Баян, Бүрэн, Батсүмбэр, Лүн, Зуунмод, Борнуур, Аргалант, Баянцогт сумд 95.03-3.27 хувиар тасалдууллаа.


Зураг II.3 Төсвийн зарлагын бүтэц салбараар, 2015 оны 1 дүгээр сарын байдлаар, хувиар



II.3 Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ

Аймгийн төвд 2015 оны 1-р сард хэрэглээний үнийн индекс суурь үе болох 2010 оны 12 дугаар сараас 52.23%, өмнөх оны мөн үеэс 7.74%, өмнөх сараас 0.41 хувиар тус тус өсөв.

Хэрэглээний үнийн аймгийн индекс (өмнөх оны 12 сар=100)



Хэрэглээний үний индексийн 2015 оны 1 дүгээр сарын 0,41 хувийн өсөлтийн 0,26 нэгж (64,65%) нь хувцас, бөс бараа, гутлын бүлгийн; 0,10 нэгж (25,74%) нь хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнийн өсөлтөөс; 0,03 нэгж (7,38%) нь гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн; 0,03 нэгж (6,52%) нь амралт чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээний бүлгийн; 0,01 нэгж (1,45%) нь бусад бараа үйлчилгээний бүлгийн үнийн өөрчлөлтөөс тус тус шалтгаалжээ.

Инфляцийн өсөлтөд үзүүлсэн бүлгүүдийн нөлөөлөл


Бараа, үйлчилгээний бүлэг	2015 оны 1 сард	
	пунктээр	хувиар
Бүгд	0.41	100.00%
01. ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	0.10	25.74%
02. СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС	0.00	0.00%
03. ХУВЦАС, БӨС БАРАА, ГУТАЛ	0.26	64.65%
04. ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	0.00	0.00%
05. ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА	0.03	7.38%
06. ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
07. ТЭЭВЭР	0.00	0.00%
08. ХОЛВООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	-0.02	-5.73%
09. АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	0.03	6.52%
10. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
11. ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
12. БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	0.01	1.45%



II.4 Хөдөө аж ахуй

2015 оны 1 сарын 1-ний байдлаар оны эхний малын 0.02 хувь буюу 761 том мал зүй бусаар хорогдсон нь 2014 оны мөн үеэс 67.4 хувь буюу 367 толгойгоор буурлаа.

Хорогдсон том малын хувийн жин – төрлөөр



Хамгийн их хорогдолтой 5 сум Мөнгөнморьт, Батсүмбэр, Алтанбулаг, Лүн, Сүмбэр, сумд оны эхний малынхаа 0.15-0.05 хувь буюу 203-21 том мал зүй бусаар хорогдуулсан нь аймгийн бүх хорогдлын 73.45 хувь (бүгд 559) эзлэв.

Зүй бусаар хорогдсон том малын тоо эхний 1 сард төрлөөр, аймгийн дүнгээр /толгой/

	2011	2012	2013	2014	2015
Бүгд	796	1116	3504	1128	761
Тэмээ		0	1		
Адуу	99	126	232	121	120
Үхэр	71	92	284	77	117
Хонь	306	429	1351	483	278
Ямаа	320	469	1636	447	246

Оны эхний адууны 0.04; үхрийн 0.04; хонины 0.01; ямааны 0.02 хувь нь тус бүр хорогдов. Бүх зүй бусаар хорогдсон малын 17.87 хувь нь өвчнөөр, 20.63 хувь нь хээлтэгч мал эзлэв.




үйлдвэрлэл, мод, модон эдлэлийн үйлдвэрлэл, цахилгаан дулааны үйлдвэрлэл, төмрийн үйлдвэрлэл өмнөх оноос 99.3-9.6 хувь буюу 184.67-2.1 сая ₮-өөр буурсан нь нөлөөлөв.

Оны эхний 1 сарын нийт үйлдвэрлэлтэнд дулааны эрчим хүч 54.35, боловсруулах үйлдвэрлэл 45.65 хувийг тус тус эзлэв.

Зураг II.8

Боловсруулах аж үйлдвэрийн зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, мянган төгрөгөөр



II.5 Аж үйлдвэр

2015 оны эхний 1 сард (2005 оны зэрэгцүүлсэн үнэнд шилжүүлснээр) 353.6 сая ₮-ийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь 2014 оны мөн үеэс 61.2 хувь буюу 558.11 сая ₮-өөр буурлаа.

Зураг II.7

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, мянган төгрөгөөр

Аж үйлдвэрийн салбар	2013 I	2014 I	2015 I	2015 I / 2014 I	%
Нийт дүн	462.03	911.74	353.63	2015 I / 2014 I	38.8%
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	12.5	3.5			0.0%
Боловсруулах аж үйлдвэр	187.18	682.79	161.42		23.6%
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	262.35	225.45	192.21		85.3%

Аймгийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл буурсан нь ашигт малтмал олборлолт, архи, ундаа үйлдвэрлэл, сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, нэхмэлийн үйлдвэрлэл, хувцас үйлдвэрлэл, арьс шир боловсруулах, үслэг арьс боловсруулалт, ширэн эдлэл, гутал

Оны үнээр нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэнд эзлэх сумдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хувийн жингээс үзэхэд Зуунмод, Баянцогт, Борнуур, Баянчандмань, Эрдэнэ, Батсүмбэр, Өндөрширээт сумд 62.12-3.09 (эдгээр сумдын үйлдвэрлэлт 86.72) хувийг, эзлэв.

Зураг II.9

Аж үйлдвэрийн салбарын борлуулалтын бүтэц, дэд салбараар, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, хувиар





II.6 Холбоо

Холбоо ашиглалтын орлого оны эхний 1 сард 22.1 сая ₮ болж, үүнээс хүн амаас орсон орлого 11.7 сая ₮ болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4 хувь буюу 0.991 сая ₮-өөр өслөө.

Шуудан холбооны албаны үйлчилгээний орлого 5.8 сая ₮ болж, нийт орлогын 61.2 хувь нь хүн амд үйлчилсэний орлого байна. Нийт орлогын 38.78 хувийг албан бичгийн, 14.64 хувийг зорчигчдын, 46.58 хувийг бусад орлого эзлэв.

Зураг II.10

Холбоо ашиглалтын орлого, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, сая төгрөгөөр

